



ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ТОГТООЛ

2024 оны 03 сарын 01 өдөр

Дугаар 10

Улаанбаатар хот

Гүйцэтгэх захирлыг чөлөөлж, шинээр томилох,  
эрх бүхий албан тушаалтнуудыг томилох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дах заалт, 84 дүгээр зүйлийн 84.2 дох заалт, Премиум Нэксус ХК ("Компани")-ийн Дүрмийн 9.4.7, 11.1.4 дэх заалт, Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")-ийн Нэр дэвшүүлэх хороо болон Цалин урамшууллын хорооны зөвлөмжийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Гүйцэтгэх захирал Г.Чинзоригийг 2024 оны 03-р сарын 01-ний өдрөөр тасалбар болгон үүрэгт ажлаас чөлөөлж, Конвينيенс дэлгүүрийн бизнесийн үйл ажиллагаа хариуцсан захирлаар томилсугай.
2. ТУЗ-ийн гишүүн А.Ганхуягийг 2024 оны 03-р сарын 01-ний өдрөөс эхлэн Компанийн Гүйцэтгэх захирлаар томилсугай.
3. Компанийн Санхүү хариуцсан захирлаар ТУЗ-ийн гишүүн Г.Бат-Эрдэнэ-г 2024 оны 03-р сарын 01-ний өдрөөс эхлэн томилсугай.
4. Компанийн эрх бүхий албан тушаалтнаар дор дурдсан албан тушаалтнуудыг тооцохоор шийдвэрлэсүгэй. Үүнд:
  - (i) ТУЗ-ийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга;
  - (ii) Гүйцэтгэх захирал;
  - (iii) Санхүү хариуцсан захирал; болон
  - (iv) Конвينيенс дэлгүүрийн бизнесийн үйл ажиллагаа хариуцсан захирал.
5. Компанийн Гүйцэтгэх захирал, эрх бүхий албан тушаалтны томилоог холбогдох зохицуулагч, бүртгэгч байгууллагуудад мэдэгдэх, бүртгэл хийлгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга (Т.Гантулга)-д даалгасугай.

(Гарын үсгийн хуудас дагалдана)



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХАРААТ БУС ДАРГА

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ГИШҮҮД:

ГАРИ БИОНДО

А.ГАНХУЯГ

А.ГАНБОЛД

Г.БАТ-ЭРДЭНЭ

З.УЯНГА

Г.ЧИНЗОРИГ

Б.БАТ-ЭРДЭНЭ

Ө.ЭРДЭНЭЧИМЭГ

В.ГАНЗОРИГ